

# ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БА ҮНДЭСНИЙ ӨВ, СОЁЛЫГ СУРГАЛТЫН АГУУЛГА, ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгаа

Судалгааны код: СТ-18/210

АГУУЛГА

УДИРТГАЛ

- БНСУ
- Сингапур
- Япон
- Финлянд
- Норвег
- Канад
- ХБНГУ
- Эстони
- Шинэ Зеланд
- Нидерланд

Ашигласан материал

## Судалгааны хураангуй

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-ын тоо мэдээнээс үзэхэд дэлхийн 218 улсаас хүүхдийг 6 наснаас нь эхлэн сургуульд хамруулдаг - 151 улс, 5 наснаас эхлэн хамруулдаг - 31 улс, 7 наснаас эхлэн хамруулдаг- 36 улс байна.

### Бага сургуульд хамрагдах эхлэх нас:

5 нас	31 улс - 14%	Австрали, Ирланд, Мальт, Мьянмар, Непал, Шинэ Зеланд, Пакистан, Их Британи зэрэг
6 нас	151 улс - 69%	АНУ, Австри, Бельги, Канад, Хятад, Хонконг, Макао, Кипр, Чех, Дани, Франц, Гүрж, ХБНГУ, Грек, Исланд, Израиль, Итали, Япон, Люксембург, Малайз, Нидерланд, Норвег, БНСУ, Сингапур, Словак, Словени, Турк, Украин зэрэг
7 нас	36 улс - 17%	Афганистан, Болгар, Хорват, БНАСАУ, Эстони, Финлянд, Унгар, Индонез, Казахстан, Кыргыз, Латви, Лихтенштейн, Литва, Польш, Молдов, ОХУ, Серби, Өмнөд Африк, Швед, Швейцар, Узбекистан зэрэг

Дэлхийн улс орнуудын ерөнхий боловсролын тогтолцоонд сүүлийн 15-20 жилийн хугацаанд хэд хэдэн үзүүлэлтээр “ижилсэх” хандлага ажиглагдаж ирсэн. Эдгээр үзүүлэлтийн тоонд: ерөнхий боловсролын сургалтын үргэлжлэх хугацаа (12 жилийн сургалттай тогтолцоо давамгайл), дунд боловсролын төгсөх ангиудад мэргэжлийн чиг баримжаа олгох, төгсөлтийн ерөнхий шалгалтын үндсэн дээр аттестатжуулах зэрэг байна.

Дэлхийн улс орнуудын хувьд дийлэнх буюу 80%-д нь ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоотой байна. ОХУ болон зарим Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орон (СНГ), Латин Америкийн зарим улс 11 жилийн тогтолцоотой байгаа бол франц, англи загварын тогтолцоо бүхий Ази, Африкийн орнууд голчлон 12 жилийн тогтолцоотой байна. Хамгийн түгээмэл хэлбэр нь бага боловсрол 4-6 жил, дунд болон ахлах сургуулиуд нь 3-5, 2-4 жил байна. Ийнхүү ерөнхий боловсролын дараах загварууд түгээмэл байна. Үүнд:

$6+3+3=12$  (хамгийн түгээмэл)

$5+4+3=12$

$6+5+2=13$

Финлянд, Дани, Швед болон АНУ-ын зарим муж улсад бага боловсрол гэж тухайлан заадаггүй ба сургуулийн анхан шатны 8-9 жилийн тогтолцоог суурь боловсрол гэж тооцдог байна.

**Мэргэжлийн чиг баримжаа олгох.** Гадаадын улс орнуудад ерөнхий боловсролын төгсөх ангид мэргэжил олгоход чиглэсэн сургалтыг 3 хувааж үздэг. Нэгдүгээрт, тодорхой хичээл, бүлэг хичээлээр сургалт явуулдаг ИБУИНВУ, АНУ-ын зарим муж улс, Канад болон Азийн зарим улс ордог. Хоёрдугаарт, хамгийн түгээмэл дэлгэрсэн загвар буюу нийгэм, байгалийн ухаан, хүмүүнлэгийн ухаан, эдийн засаг, технологийн зэргээр хуваарилдаг

Франц, Бельги, БНСУ болон бусад орнууд. Гуравдугаар загварт, ирээдүйд эзэмших мэргэжлийн чиглээр сургалт явуулдаг ХБНГУ (хэсэгчлэн), Швед зэрэг орж байна. Практикт мэргэжил олгоход чиглэсэн сургалтын холимог тогтолцоо түгээмэл дэлгэрсэн байдаг ба энэ нь 2-3 үндсэн чиглэлийн хүрээнд сургалт явагдсаны дараагаар илүү мэргэшүүлсэн чиглэлд шилжих загвар юм.

### ***Гадаад хэлний сургалт***

Бага боловсролын хүрээнд хүүхдэд гадаад хэлийг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зааж эхлэх насны хувьд:

- БНСУ-д бага сургуулийн 3 дугаар ангиас;
- Сингапурт бага сургуулийн 1 дүгээр ангиас англи болон эх хэл (малай, мандарин, тамил);
- Японд гадаад хэлийг 7-р ангиас; (гадаад хэл зааж эхлэхээс өмнө япон хэл, соёлыг бүрэн танин мэдсэний дараа гадаад хэл заах нь үр дүнтэй гэсэн бодлогыг баримталдаг байна).

Европын орнуудын хувьд: 1995 оны Европын холбооны Цагаан баримт бичигт “суурь сургалтыг дүүргэснээр хүн бүр Холбооны 2 гадаад хэлийг эзэмшсэн байна” гэж заасан, 2000 оны Лисабоны Саммитаар гадаад хэлний мэдлэгийг 5 үндсэн чадварын тоонд оруулсан байна. 1990-ээд оноос олон улсын гадаад хэлний “Common European Framework of Reference for Languages” стандартыг нэвтрүүлж, гадаад хэлний сургалтыг нийцүүлэх, уялдуулах ажлууд хийгдэж ирсэн байна.

1974 онд Европын холбооны гишүүн орнуудаас Ирланд, Их Британиас бусад бүх оронд заавал судлах хичээлийн тоонд нэг гадаад хэл орж байсан бол 1998 онд Ирландаас (Ирланд болон Ангил хэл дээр хичээл явагдах боловч, аль нь ч гадаад хэлд тооцдоггүй, түүнчлэн гурав дахь гадаад хэлийг заадаг) бусад бүх оронд гадаад хэлний сургалт суурь боловсролын тогтолцоонд багтсан. Бельги, Франц, Дани, Нидерланд, Герман, Люксембург, Финлянд, Швед, Исланд, Швейцар, Грек, Хорват, Кипр, Эстони, Латви, Литва, Польш, Румын, Серби, Словени болон Словак зэрэг улсын ахлах дунд боловсролын сургуулиудын сурагчид доод тал нь хоёр гадаад хэл судалдаг байна.

Европын хэмжээнд гадаад хэлний анхан шатны хичээл долоо хоногт 3-4 цагаар ордог ба бага сургуулийн төгсөлд, эсхүл дунд сургуулийн эхэнд гадаад хэл дээрх хичээлүүдийг зааж эхэлдэг байна. Люксембург, Норвег, Итали, Мальт зэрэг улсад нэгдүгээр гадаад хэлийг 6 наснаас, Шведэд 7 наснаас, Бельгид 10 наснаас тус тус зааж эхэлдэг байна.

### ***Үндэсний өв, соёлыг сургалтын хөтөлбөр, агуулгад тусгасан байдал***

Судалгаанд хамрагдсан 10 улсын хувьд ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөр, агуулгад үндэсний өв соёлыг хэрхэн тусгасныг авч үзвэл эх хэл, уран зохиол, түүх, газар зүй, нийгмийн ухаан, дуу хөгжим зэрэг хичээлүүдээс гадна ёс зүй/ёс суртахууны хичээл (БНСУ, Япон), иргэний боловсролын хичээл (Сингапур), библи судлал (Норвег) зэрэг хичээлийн хөтөлбөрт туссан байна.

Улаанбаатар  
2018 он

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГААНЫ АЛБА